

Түүх 11 : Элч Паул

Библийн эшлэл
[Үйлс 9:15]

Харин Эзэн, түүнд – Яв, учир нь тэр бол харийнхан, хаад болон Израилийн хөвгүүдийн өмнө нэрийг минь авч явахаар Надад сонгогдсон сав бөгөөд

Саул маш ухаантай хүн байв. Гэвч тэр Есүст итгэдэггүй байлаа. Бүр Есүст итгэдэг хүмүүсийг үзэн ядаж, шоронд барьж хорьдог ажлыг хийдэг байв. Саул ахлах тахилчид очоод ингэж хэлэв.

“Есүст итгэдэг хүнтэй үүлзвал хэн ч бай заавал Иерусалим уруу барьж ир гэсэн захиаг бичиж өгөөч.”

Саул ингэж Есүсийн дагалдагчдийг барихаар Дамаск руу явлаа.

Саул Дамаскт дөхөн иртэл гэнэт тэнгэрээс нүд гялбам хурц гэрэл тусав. Саулын нүд гялбаж харж чадахгүй байв.

Саул гараараа нүүрээ халхалсан ч гэрэл маш хурц байсанд юу ч харж чадахгүй байлаа.

Тэр үед тэнгэрээс нэгэн дуу сонсогдов. “Саул аа, Саул аа, чи юунд Намайг хавчина вэ?”

Саул ингэж асуув. “Та хэн бэ?” Есүс ингэж хариулав. “Чиний хавчиж байгаа Есүс байна.”

Саул, Есүс бол амлалтын Хаан, загалмайд цовдлогдож нас бараад амилсан гэдэгт хүртэл итгэдэггүй байв.

Тэгээд Есүсийн дуу хоолойг сонсоод ихэд гайхав.

Юм харж чадахаа больсон Саул хамт явсан хүмүүстэйгээ хамт Дамаскт хүрч очив.


Саул Дамаскд очоод гурав хоногийн турш юу ч харж чадахгүй бас юу ч уухгүй, юу ч идсэнгүй.

Саул буруу зүйл хийснээ ойлгож Есүст хандан чин сэтгэлээсээ залбирав.

Тэр үед Дамаскд Ананиа хэмээх Есүсийн дагалдагч амьдарч байв. Есүс Ананиагийн зүүдэнд үзэгдэж дуудав.

“Тэр намайг мэдэхгүй хүмүүс болон хаад, Израилийн ард түмэнд Миний Нэрийг дамжуулахын төлөө сонгогдсон Миний сав учраас түүнд гар тавьж түүнийг эдгээхтүн” гэж хэлэв. Харин Ананиа,

Саулын тухай сонссон бөгөөд тэрээр Есүст итгэдэг хүмүүсийг их зовоодог гэдгийг сонсчихоод тийшээгээ явах ихэд дургүй байв. Гэхдээ Есүс айлдсан учраас Саулыг хайж олоод толгой дээр нь гар тавин залбирав.





Ананиагийн залбирал дуусмагц, Саулын нүднээс хайрс шиг зүйл унаж Саул дахин хараа оров. Тэгээд Саул босон Ананиагаасс усан баталгаа хүртэв. Тэгээд Саул босон Ананиагаасс усан баталгаа хүртэв.

Саул хоол унд идэж тэнхрэн Дамаскд буй дагалдагч нар болон Есүст итгэдэг хүмүүстэй хэд хоног хамт байв.

Тэгээд өөртэй нь уулзсан Есүс бол Бурханы Хүү болохыг дамжуулав.

Олон хоног өнгөрсний дараа Иудейчүүд Саулыг барьж алахын тулд дааман хаалгануудын дэргэд өдөр шөнөгүй отон хүлээж байв. Гэвч Саул тэдний төлөвлөгөөг мэдсэн байлаа.

Тэгээд Саулын дагалдагч нар шөнө дунд түүнийг сагсанд хийн цайзын гадна гаргаж зугтаалгав.

Энэ Саул бол алдартай сайн мэдээ тараагч Паул юм.

Паул хэцүү зовлонтой олон зүйлтэй тулгарсан ч тэр олон орноор явж Есүсийн тухай ярьсаар байв.

Мөн Тэрээр Шинэ гэрээний 27 номноос 13-ийг нь бичсэн юм.



a. Саул Хэнийг хавчиж, дарлаж байсан бэ?

b. Саулыг Дамаск уруу явах замд нь юу тохиолдсон бэ?


c. Есүс зүүдээр дамжуулан хэнд үгээ айлдсан бэ?

d. Саулд тохиолдсон бүх зүйлийн дараа тэрээр хэрхэн өөрчлөгдсөн бэ? Түүний шинэ нэр нь хэн байсан бэ?

● Дараах библийн эшлэлийг уншаад цээжлээрэй. (Үйлс 9:15)

Учир нь тэр бол харийнхан, хаад болон Израилийн хөвгүүдийн өмнө нэрийг минь авч явахаар
Надад сонгогдсон сав бөгөөд

Бүтээлч байцгаая 2. Ананиаг нүд нь сохорсон Саултай уулзахад нь туслаарай.





Нәр :